



## Гэр бүлийн хүчирхийллийн эрсдэлийг илрүүлэх асуумж

Өвчтөнд зориулсан мэдээлэл (in Mongolian)

Австрали улсад хүн бүр аюулгүй амьдрах эрхтэй. Австралид эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй адил тэгш эрхтэй. Хамтран амьдрагч, эхнэр, нөхөр эсвэл гэр бүлийн гишүүндээ хүч хэрэглэж, гэмтээх нь хууль зөрчсөн үйлдэл юм. Хэрэв хэн нэгэн таныг айдаст автуулж, аюултай мэдрэмж төрүүлж байгаа эсвэл танд хор хүргэж байгаа бол бид танд тусалж чадна. Хэрэв та хүүхэдтэй бол хүүхдийг тань хамгаалахад мөн тусалж чадна.

Доорх асуултуудыг уншаад “Тийм” эсвэл “Үгүй” гэсэн хариултыг бөглөнө үү. Хэрэв хүсвэл бид орчуулагчтай утсаар холбогдон энэ талаар дэлгэрэнгүй ярилцах боломжтой.

Асуулт	Тийм	Үгүй
Танай гэрт байдаг хэн нэгнээс, хуучин хамтрагч эсвэл гэр бүлийн гишүүнээсээ та айж эмээдэг үү?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Танай гэр бүл, өрх гэрийн гишүүн эсвэл өмнөх харилцааны хүн таныг гэмтээж байсан эсвэл гэмтээхээр заналхийлж байсан уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Та дараах зүйлсийн аль нэгэнд санаа зовж байна уу? • Өөрийн аюулгүй байдал • Таны хүүхдийн аюулгүй байдал* • Танай гэр бүл эсвэл өрхийн өөр хэн нэгний аюулгүй байдал	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Хэрэв тийм бол энэ асуудлаар яг одоо тусламж авахыг хүсэж байна уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Хэрэв та дээрх асуултуудын аль нэгэнд “Тийм” гэж хариулсан бол эмнэлгийн ажилтнууд таны аюулгүй байдлын талаар тань нэмэлт асуулт асууж, шаардлагатай тохиолдолд тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллагад холбон өгч болно.



Women and Newborn Health Service  
King Edward Memorial Hospital

📍 374 Bagot Road, Subiaco WA 6008

☎ (08) 6458 2222

🌐 [kemh.health.wa.gov.au](http://kemh.health.wa.gov.au)

Энэхүү баримт бичгийг хүсэлтийн дагуу өөр хэлбэрээр гаргаж болно.